ББ маркын ажлын зургийн үндсэн бүрдлийн жагсаалт

Д/Д	Зургийн нэр	хуудасны марк	тайлбар
1	2	3	4
1	Зургийн жагсаалт, тайлбар бичиг	ББ-1	
2	Суурь суулгалтын зураг	ББ-2	
3	Суурийн байгуулалт, огтлол, түүвэр	ББ-3	
4	Ялууны байгуулалт, дулаалгын гаднах өрлөгийн бэхэлгээ	ББ-4	
5	Хэсэглэл А, Б, огтлол 1-1, тор Т-1, УХ-1, материалын түүвэр	ББ-5	
6	Хучилтын хэвний байгуулалт, бүсний арматурчлал	ББ-6	
7	Хучилтын арматурчлал, огтлол, түүвэр	ББ-7	
8	Шувуу нурууны байгуулалт, огтлол	ББ-8	
9	Шувуу нурууны хэсэглэл	ББ-9	
10	Модон саравчны байгуулалт, огтлол, түүвэр	ББ-10	

Тайлбар бичиг

Ерөнхий хэсэг: Барилга бүтээцийн төлөвлөлтийг байгаль цаг уурын доорхи нөхцөлд тохируулан төлөвлөв.

Үүнд: Гадна агаарын тооцооны температур -29.0°С

цасны ачаалал 30кг/м2

салхины ачаалал 47кг/м2

газар хөдлөлийн балл 5 балл

Барилга нь тэнхлэгээрээ 12.0м х 8.4м хэмжээтэй даацын тоосгон ханатай, цутгамал төмөр бетон хучилттай, шувуу нуруу дээвэртэй нэг давхар барилга болно.

Суурь: Барилгын инженер геологийн "Экотех проект" ХХК-д боловсруулсан архив №006/020 геологийн дүгнэлтийн дагуу суурь суух буурь хөрс нь хар хүрэн өнгийн хатуу хам байдалтай делюви-пролювийн гаралтай дөрөөдөгчийн настай хайргархаг элсэнцэр хөрс болно. Уг хөрс нь улирлын хөлдөлтийн бүсэд сулавтар овойлт үүсгэнэ. Хөрсний улиралын хөлдөлтийн норматив үүн -2.75м. Газар шороony ажлын эзэрэг нь гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад -III байна. Тус талбай газар чичирхийллийн 5 баллын бүсэд багтана. Суурь суух буурь хөрс нь зургаг зааснаас шинж үзүүлэлт эөрүүтэй өөр төрлийн хөрс илэрвэл холбогдох хүмүүст мэдэгдэж, техникийн шийдвэр гаргуулах хэрэгтэй.

Суурь: Котлованы механизмаар ухахдаа суурь суулгах төслийн түвшингээс дээш 20-30см дутуу ухаж түүнээс доош төслийн түвшин хүртэл гараар ухах хэрэгтэй. Барилгын суурийг цутгамал бетон шугаман суурьтайгаар төлөвлөв. Цутгамал бетон шугаман суурийн бетоны анги В15 байна. Шугаман суурийн доор 10см зузаан В10 ангийн бетон бэлтгэл хийнэ. Барилгын суурийн хөрстэй харьцах гадаргууд 2 үе хар тосон түрхлэг түрхэх ба овойлт үүсгэдэггүй элс хайрган хөрсөөр бүцаж чигжинэ. Бетоны ажлыг гүйцэтгэхдээ "Цутгамал бетон, төмөр бетон бүтээц" БНбД52-02-05, "Цутгамал төмөр бетоны ажил гүйцэтгэх заавар" БД52-102.04-н заалтуудыг баримталбал зохино.

Гадна хана ба хамар хана: Гадна хана нь 38см-н тоосго, 10см-н хөөсөн полистрол хавтан, 12см-н өнгөлгөөний тоосго, 2см шавардлага хийж гадна өнгөлгөөний эмульсээр БА-н зураг заасан кодын дагуу өнгө гаргаж 2 үе будна Дотор даацын хана нь 38см, хамар хана нь 12см-н тоосгон хана байна. Гадна 12 см тоосгон хана ба үндсэн ханын өргийг эзэрэг гүйцэтгэвэл зохино. Дулаалгын хөөсөн полистрол хавтан нь MNS EN 13163-2011-н марк-25, эзэлхүүний нягт-25кг/см3, дулаан дамжуулалтын итгэлцүүр-0.041 нэгж байх шаардлагыг хангах ёстой.

Гадна хана ба дотор ханын өргийн ажлыг гүйцэтгэхдээ "Өрөгт бүтээц" БНбД3.03.05-90-ийн дагуу гүйцэтгэх хэрэгтэй. Өргийн эзэрэг II, нормаль барьцалдалт нь 1.2кг/см2<R <1,8кг/см2 байна. Тоосгон ханыг М75-с багагүй маркийн ердийн улаан тоосго, М25-с багагүй маркийн холимог (цемент+шохойн+элс) зуурмагаар өрнө. Дулаалгын хөөсөнцөр хавтангийн гадна талын 12-н тоосгон ханыг зураг төсөлд болон цуврал Г1.030.1-3Г дэвтэр.4-д заасаар бэхлэнэ.

Өргийн ажлыг дулааны улиралд гүйцэтгэхээр зураг төсөлд тусгасан ба хэрэв хасах температуртай үед гүйцэтгэх бол өргийн зуурмагийн маркийг нэг шат ахиулан авна. Мөн зуурмагийн бэхжилтийг хангах нэмэлтийг зуурмагт хэрэглэсэн нөхцөлд хүйтний улиралд өргийг гар аргаар гүйцэтгэж болно.

Хучилт: Хучилтыг цутгамалаар гүйцэтгэхээр зураг төсөлд тусгасан. Цутгамал хучилтын ажлыг ББ-8-д үзүүлснийн дагуу хийнэ. Цутгамал хучилтын арматурчлалыг төмөр бетон бүсний арматурчлалтай хамт хийж хамт цутгана. Цутгамал төмөр бетоны ажлыг гүйцэтгэхдээ "Цутгамал бетон, төмөр бетон бүтээц" БНбД52-02-05, "Цутгамал төмөр бетон бүтээцийн ажил гүйцэтгэх заавар" БД52-102-04-н заалтуудыг баримталбал зохино. Хэв хашмал нь бат бэх, тогтвортой нөхцөлөөр хангагдсан байх шаардлагатай ба бетон бат бэхийн бэхжилтийнхээ 70%-ийг авахаас өмнө хэв хашмалыг суллаж болохгүй. Бетоны анги В.20, ажлын арматурын анги AIII, хөндлөн арматур AI.

Шувуу нурууны ул нуруу бэхлэх гарталгаа арматурыг зураг үзүүлний дагуу төмөр бетон бүсэнд байрлуулж өгнө.

Ялуу: Ялуу ханын өргөний хэмжээгээр тавих бөгөөд 1500мм хүртэл өргөнтэй нүхэн дээр 250мм-с багагүй, 1500мм-с дээш өргөнтэй нүхэн дээр 350мм-с багагүй хэмжээтэй суулгана. Угсармал төмөр бетон ялуг М50 маркийн жигд тараасан бэхжээгүй зуурмаг дээр суулгана.

Хаяавч: Барилгын эргэн тойронд 120 см өргөнтэй манаасыг В10, F75, W6 ангийн бетоноор 8-12см-н зузаантай цутгаж 2 см цементэн өнгөлгөө хийнэ.

ТӨГСШУГАМ КОНСТРАКШН ХХК	Мэдээллийн төвийн нэг загварын байр Дорноговь аймаг. Даланжаргалан сум, Бичигт баг			
	Суурь суулгалтын зураг			Үе шат: А.3
	Инженер Н.Мягмарсүрэн	Е.Г.Шифр: АЗТ-01/2020-ЦБ	Масштаб:	Огноо: 2020.01
	Гүйцэтгэсэн Н.Мягмарсүрэн	Т.Г.Шифр: ТШК-20-02	Зургийн дугаар: ББ-10	Хуудас: 1
	Шалгасан Г.Амарзаяа			

А3